



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1164

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.2-ын "д", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний ажлын хүрээнд, хөрөнгийн эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах, асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх зорилгоор Хэнтий аймаг дахь Цахилгаан Түгээх салбарын эзэмшилд байгаа дизель станцын ашиглалт, хадгалалтын талаарх шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүд.	Б.Наранбаяр	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Жанчив	-Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн
	О.Баяртөгс	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
	Ч.Оюунболд	-БНЗӨБЦТС-ийн ерөнхий инженер

2. Хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалттай холбоотой ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор хийж гүйцэтгэж ажлын тайлангийн дүнг гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Дэмбэрэлсайхан/-д даатгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 759

D:\My Documents\Захирамж 2017.doc